



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН  
ТАНАА

2025.06.27 № 2024  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


**Аудитын тайлан хүргүүлэх тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгсөн аудитын тайланг Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн,



СМАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2025 оны 06 дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: МОНГОЛ  
УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
АУДИТЫН ДҮГНЭЛТ**



## АГУУЛГА

<b>НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>6</b>
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ</b> .....	<b>7</b>
Нэг. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн өөрчлөлт нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх.....	7
Хоёр. "Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцсэн байна. ....	8
<b>ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ОРЛОГО:</b> .....	<b>9</b>
<b>ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ЗАРЛАГА:</b> .....	<b>10</b>
Нэг. Төсвийн урсгал зардал.....	10
Хоёр. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал: .....	12
<b>ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ:</b> .....	<b>14</b>
<b>ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:</b> .....	<b>14</b>
<b>ДОЛОО. ДҮГНЭЛТ</b> .....	<b>15</b>

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал .....	7
Хүснэгт 2. Монгол улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар .....	8
Хүснэгт 3. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ.....	9
Хүснэгт 4. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ.....	10
Хүснэгт 5. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар.....	11
Хүснэгт 6. Улсын төсвийн урсгал зардлын харьцуулсан дүн .....	11
Хүснэгт 7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж.....	12
Хүснэгт 8. Шинээр хэрэгжүүлэхээр нэмж төлөвлөсөн төсөл, арга хэмжээ .....	13
Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл .....	14

### Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө .....	17
Хавсралт 2. Монгол улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл .....	19
Хавсралт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын тодотгосон нийт зардал.....	19
Хавсралт 4. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний судалгаа.....	20
Хавсралт 5. Татан буулгах хороо, зөвлөлийн судалгаа.....	20



**Аудит хийх  
үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилго**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан бүрэн эрх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг үндэслэн гүйцэтгэлээ.

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль эрх зүйн хүрээнд арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх доорх асуултад хариулт өгөх зорилго тавьсан. Үүнд:

- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголыг үндэсний аюулгүй байдал болон улсын тогтвортой хөгжлийн бодлого, бодит шаардлагад нийцүүлж, эрх зүйн хүрээнд гүйцэтгэсэн эсэх;
- ✓ Төсвийн тодотгол нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- ✓ Төсвийн төслийг Засгийн газрын шинэчилсэн бүтэц бүрэлдэхүүн, чиг үүргийн өөрчлөлтөд нийцүүлж боловсруулсан эсэх;
- ✓ Төсвийн орлого, зардлын өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд хийсэн төсвийн зохицуулалтыг бодит шаардлага, тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөсөн эсэх;
- ✓ Төсвийн тодотголыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх;
- ✓ Төсвийн тодотголоор нэмж төлөвлөсөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж, хууль болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- ✓ Төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөсөн эсэх.

**Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад холбогдох заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсвийн тодотголыг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

**Аудитын хамарсан  
хүрээ**

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, бусад тусгай сангууд/-ийн 2025 оны батлагдсан төсөв, 2025 оны 5 дугаар сарын байдлаарх төсвийн гүйцэтгэл /урьдчилсан/, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчид



**Талуудын хүлээх  
үүрэг, хариуцлага**

болон төсөл хөтөлбөрүүдэд орсон өөрчлөлт, үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад нэмж тусгасан хөтөлбөр арга хэмжээний мэдээ, тооцоо холбогдох баримт, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүү, төсвийн мэдээ, үндсэн үзүүлэлтийг хамруулан гүйцэтгэв.

Засгийн газар нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн жилийн төсөвт тодотгол хийнэ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22, 23 дугаар зүйл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5, 6, 7, 8 дугаар зүйлд заасан зарчим, шаардлагын дагуу, боловсруулж, төсөв, танилцуулгын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төрөөс баримтлах хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.

**Аудитын бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын Орлогч З.Цэдэнжав, Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг хэрэгжүүлж, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, Б.Долгоржав, Ш.Наран, Л.Нямтөмөр, Б.Ариунжаргал, аудитор Г.Оюунтөгөлдөр, Т.Баасанцэнд, Б.Батхишиг, С.Билгүтэй, Я.Марал-Эрдэнэ, Э.Цэлмэгбаяр, Э.Бат-Эрдэнэ, Н.Нямсүрэн болон Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

**Хүндрэл бэрхшээл**

Төрийн аудитын байгууллагаас тухай жилийн төсвийн тодотголд аудит хийх талаарх эрх зүйн зохицуулалт тодорхой бус, Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гарган Улсын Их Хуралд өргөн барих, хэлэлцүүлэх цаг хугацаа нэн хязгаарлагдмал байгаа нь хүндрэл бэрхшээл үүсгэсэн.



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ЗГХЭГД	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ОН	ОРОН НУТАГ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
УЕП	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ХЗДХС	ХУУЛЬ, ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД
ХНХС	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ЦХХХС	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
ЦДАШ	ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ
ШЕЗ	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ЭЗХЯ	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭМДС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ЭХС	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### **Монгол Улсын 2025 оны 5 сарын байдлаарх макро эдийн засгийн төлөв байдал, төсвийн тодотгол хийх үндэслэл, төсөвт орсон өөрчлөлт**

1.1. Монгол Улсын 2025 оны эхний улирлын байдлаарх нэрлэсэн ДНБ 19,000.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, мөнгөний нийлүүлэлт 41,544.9 тэрбум төгрөг, ажиллах хүчний оролцооны түвшин 61.7 хувь, инфляцын түвшин 8.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна<sup>1</sup>.

1.2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тодотголыг боловсруулахад үндэслэл болгосон макро эдийн засгийн төлөв байдлын төсөөллөөр эдийн засгийг 5.5 хувиар өсөхөөр, гадаад худалдааны нийт бараа эргэлтийг 28.3 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 3.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар, нийт экспорт 2025 онд 15.8 тэрбум ам.доллар, нийт импорт 12.5 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна. Экспортод гарч буй нүүрсний дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар тонн тутамд 71.9 ам.долларт хэлбэлзсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 39 хувиар буюу 46.6 ам.доллаароор буурсан. Нүүрсний үнэ буурснаас шалтгаалж манай улсын экспорт 2025 оны эхний 5 сарын байдлаар 5,424.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буюу 932.9 сая ам.доллаароор буураад байгаа болно.

1.3. УИХ-аас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 33,470.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 33,470.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар баталжээ.

1.4. УИХ-аас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 33,469.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 33,431.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 38.4 тэрбум төгрөгийн ашигтай байхаар тус тус баталсан.

1.5. Гүйцэтгэлийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр авч үзвэл Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 10,711.6 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 10,971.5 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл (259.9) тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

1.6. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулж Ерөнхий сайд, 19 Засгийн газрын гишүүдтэйгээр танхимаа бүрдүүлсэн болон геополитикийн хурцадмал байдал гүнзгийрч, гадаад орчны сорилт нь манай улсын эдийн засагт хүндрэлтэй нөхцөл байдал бий болгохоор байгааг харгалзан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгосон байна.

1.7. Ийнхүү Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4-т заасан төсөвт тодотгол хийх нөхцөл бүрдсэн тул Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.8. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 30,209.9 тэрбум төгрөг буюу, нийт зарлагын дээд хэмжээг 31,575.1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (1,365.2) тэрбум төгрөг буюу ДНБ-ийн 1.5 хувийн алдагдалтай, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 28,401.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.6 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,808.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байх, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

<sup>1</sup> Эх сурвалж: ЭЗХЯ-ны Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл



1.9. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслөөр нэгдсэн төсвийн дараах үзүүлэлтүүдийг өөрчлөн төлөвлөсөн байна. Үүнд:

- Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3,260.0 тэрбум төгрөгөөр бууруулж 30,209.9 тэрбум төгрөг;
- Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 1,856.4 тэрбум төгрөгөөр бууруулж 31,575.1 тэрбум төгрөг;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2025 онд хуримтлуулах дүнг (179.8) тэрбум төгрөгөөр бууруулж 429.1 тэрбум төгрөг;

1.10. Олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засгийн тодорхойгүй байдлаас хамаарч 2025 онд дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, мөн түүхий эдийн томоохон хэрэглэгч Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хүндрэлээс шалтгаалан тус улсын эдийн засгийн өсөлт болон гангийн эрэлт буурч байгаа нь манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэд нөлөөлж байна. Тухайлбал 2025 оны эхний таван сарын байдлаар манай улсын нүүрсний экспортын дундаж үнэ тонн тутамд 71.9 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 46.6 ам.доллараар буюу 39.0 хувиар буурсан нь 2025 оны төсөвт төвлөрүүлэхээр тооцсон тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 3.3 их наяд төгрөгөөр багасахад хүрээд байна.

1.11. Иймд Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголыг төрийн чиг үүргийг оновчтой зохион байгуулж, цомхон, чадварлаг бүтцээр төрийн үйлчилгээг үр ашигтай хүргэх чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тухайлбал, чиг үүргийн давхардлыг арилгаж ажлын ачааллыг нягтруулах, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг шалган баталгаажуулах, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалтад шинэчлэл хийх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хүнд суртал, шат дамжлагыг бууруулах зэргээр төрийн зардлыг бууруулах бодлогын арга хэмжээнд чиглэсэн байна.

## **ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ**

2.1. ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Мөн ЗГ-ын нэрлэсэн үнээр тооцсон өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2025 онд 44.5 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

### **Нэг. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн өөрчлөлт нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх**

2.1.1 Монгол Улсын ЗГ-аас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засгийн өсөлтийн удаашрал, ЗГ шинээр байгуулагдаж бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2<sup>2</sup>, 34.1.4<sup>3</sup> дэх заалтыг үндэслэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

2.1.2. Төсвийн тодотголоор Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын ажлын алба, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын ажлын алба, Монгол Улсын сайд, 20 минутын хот-Үндэсний хорооны даргын ажлын албыг татан

<sup>2</sup> Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;

<sup>3</sup> төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх;



буулгаж, чиг үүргийг харьяалагдах төсөв захирагчид шилжүүлснээр 8.4 тэрбум төгрөгийн урсгал зардал буюу цалин, хөлс, урамшууллын зардлыг хэмнэхээр төлөвлөсөн. Үүнд:

- ✓ Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын ажлын албыг Сангийн сайдын чиг үүрэгт шилжүүлснээр 1.5 тэрбум төгрөг;
- ✓ Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын ажлын албыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын чиг үүрэгт шилжүүлснээр 5.5 тэрбум төгрөг;
- ✓ Монгол Улсын сайд, 20 минутын хот-Үндэсний хорооны даргын ажлын албыг Барилга хот байгуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудалд шилжүүлж 1.4 тэрбум төгрөг байна.

Хуулиар тусгайлан байгуулаагүй 7 хороо, 3 зөвлөл болон тэдгээрийн ажлын албыг татан буулгаж 11.2 тэрбум төгрөгийн цалин хөлс, урсгал зардлыг хэмнэхээр төлөвлөжээ.

**Хоёр. "Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцсэн байна.**

2.2.1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл болон тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд тусгасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна. Үүнд:

- ✓ Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон;
- ✓ Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,808.2 тэрбум төгрөгийн үр дүнтэй буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү;
- ✓ Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 26.7 хувь буюу тусгай шаардлагаар тогтоосон 30 хувиас хэтрээгүй байна;
- ✓ Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 44.5 хувь буюу тусгай шаардлагаар тогтоосон 60 хувиас хэтрээгүй.

*Хүснэгт 1. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал*

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Тодотгосон төсвийн төсөлд тусгасан байдал	Тусгай шаардлага хангасан байдал
1	6 дугаар зүйлийн 6.1.1. "нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх"	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 129.0 ам.доллар байхаар тооцсон байна.	6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан тусгай шаардлагыг хангасан байна
2	6 дугаар зүйлийн 6.1.2-т "Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх"	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 30,209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 28,401.7 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,808.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байхаар тооцсон байна.	6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг хангасан байна
3	6 дугаар зүйлийн 6.1.3-т "нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх"	Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ 24,005.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 26.7 хувьтай байна.	6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан тусгай шаардлагыг хангасан
4	6 дугаар зүйлийн 6.1.4-т "Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх"	ЗГ-ын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 40,021.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд үүний ДНБ-д эзлэх хэмжээ 44.5 хувьтай тэнцүү байна.	6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан тусгай шаардлагыг хангасан

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллага*



2.2.2. ЗГ-ын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийг тооцохдоо гадаад болон дотоод өр 33,415.1 тэрбум төгрөг, орон нутгийн зээллэг 2,598.2 тэрбум төгрөг, Засгийн газрын өрийн баталгаа 4,007.9 тэрбум төгрөгийг оруулан тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Энэ хуулийн 6.1.4-т заасан ЗГ-ын өрийн хязгаарт ЗГ-ын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ОРЛОГО:

3.1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийт орлого ба тусламжийн дүнг 2025 оны батлагдсан төсвөөс 3,895.4 тэрбум төгрөгөөр бууруулж, 32,540.2 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна.

Хүснэгт 2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
	Батлагдсан	Тодотгол		
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>36,435.6</b>	<b>32,540.2</b>	<b>(3,895.4)</b>	<b>(10.7)</b>
Тогтворжуулалтын сан	608.9	429.1	(179.8)	(29.5)
Үндэсний баялгийн сан	2,356.8	1,901.2	(455.6)	(19.3)
<b>Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>33,469.9</b>	<b>30,209.9</b>	<b>(3,260.0)</b>	<b>(9.7)</b>
Татварын орлого	31,557.2	28,346.7	(3,210.5)	(10.2)
Татварын бус орлого	1,912.7	1,863.2	(49.5)	(2.6)

Эх сурвалж: Сангийн яам

3.2. Төсвийн тодотголоор 2025 оны батлагдсан төсвөөс тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлогыг 179.8 тэрбум төгрөгөөр бууруулж 429.1 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон нь нүүрсний зах зээлийн дундаж үнийг тонн тутамд 70 ам.долларт байхаар тооцсонтой холбоотой байна.

3.3. Төсвийн тодотголоор 2025 оны батлагдсан төсвөөс Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх орлогыг 455.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 1,901.2 тэрбум төгрөгөөр тооцсон байна.

3.4. Төсвийн тодотголоор төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 2025 оны батлагдсан төсвөөс 3,260.0 тэрбум төгрөгөөр бууруулж, 30,209.9 тэрбум төгрөгөөр буюу ДНБ-ий 33.6 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн байна. Үүнд: Татварын орлогыг 3,210.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлогыг 49.5 тэрбум төгрөгөөр бууруулж төсөвлөсөн нь голлон нөлөөлж байна.

3.5. Төсвийн тодотголоор тэнцвэржүүлсэн орлого болон ДНБ-д эзлэх хувь хэмжээ нь 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн хязгаараас 3,260.1 тэрбум төгрөгөөр хэтэрсэн боловч шинэчилсэн хуулийн төсөлтэй нийцэж байна.

3.6. Нүүрсийг 2025 онд 83.3 сая тонныг экспортлохоор төлөвлөснөөс 5 дугаар сарын байдлаар 38.3 хувийн гүйцэтгэлтэй буюу 31.8 сая тонн нүүрсийг экспортолсон байна.

3.7. Нүүрсний үнийг 2025 онд тонн тутамд 105.0 ам.доллар байхаар тооцсон, эхний 5 сарын байдлаар нүүрсний үнэ тонн тутамд 71.9 ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 39 хувиар буурсан тул нүүрсний үнийг тонн тутамд 70 ам.долларт хэлбэлзэхээр тооцсон байна.

3.8. Боловсруулаагүй нефтийн биет хэмжээг 3,875.0 сая баррель тутамд 75.0 ам.доллар буюу 249.7 тэрбум төгрөгөөр төсөвлөж, 98.2 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.



**Хүснэгт 3. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ**

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	х/н	Биет хэмжээ		Үнэ, ам доллар/нэгж		Орлого /тэрбум төгрөг/		
			2025 он		2025 он		2025 он		
			Бат	Тод	Бат	Тод	Бат	Тод	Зөрүү
1	Нүүрс	сая.тн	83.3	85.0	105.0	70.0	7,125.5	4,333.1	(2,792.4)
2	Зэсийн баяжмал	сая.тн	1,780.0	2,030.0	10,000.0	9,200.0	2,949.7	2,838.3	(111.4)
3	Алт, тушаасан (цэвэр жингээр)	тн, \$/унц	18.0	16.5	1,850.0	2,900.0	342.8	402.8	60.0
4	Төмрийн хүдэр	сая.тн	9,000.0	8,110.0	65.0	72.0	333.1	297.6	(35.5)
5	Боловсруулаагүй нефть	сая.бар	5,390.0	3,875.0	77.0	75.0	347.9	249.7	(98.2)
6	Бусад	-	-	-	-	-	590.4	665.2	74.8
<b>Дүн</b>							<b>11,689.4</b>	<b>8,786.7</b>	<b>(2,902.7)</b>

Эх сурвалж: Сангийн яам

3.9. Улсын төсвөөс 2025 онд аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ 599.1 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 30.5 хувь буюу 182.7 тэрбум төгрөгөөр бууруулж, 416.4 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна.

**Хүснэгт 4. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ**

Д/д	Аймаг, нийслэл	2025 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
		Батлагдсан	Тодотгосон		
1	Архангай	14.6	9.7	(4.9)	2.7
2	Баян-Өлгий	14.0	9.4	(4.6)	2.5
3	Баянхонгор	23.5	18.1	(5.4)	3.0
4	Булган	15.3	11.1	(4.2)	2.3
5	Говь-Алтай	25.0	18.3	(6.7)	3.7
6	Говьсүмбэр	8.5	5.8	(2.7)	1.5
7	Дархан-Уул	21.3	13.2	(8.1)	4.4
8	Дорноговь	55.7	33.4	(22.3)	12.2
9	Дорнод	30.4	23.0	(7.4)	4.1
10	Дундговь	18.2	13.0	(5.2)	2.8
11	Завхан	17.3	12.4	(4.9)	2.7
12	Орхон	38.7	26.2	(12.5)	6.8
13	Өвөрхангай	17.3	12.2	(5.1)	2.8
14	Өмнөговь	60.8	43.8	(17.0)	9.3
15	Сүхбаатар	26.6	19.7	(6.9)	3.8
16	Сэлэнгэ	31.3	23.1	(8.2)	4.5
17	Төв	28.9	25.0	(3.9)	2.1
18	Увс	16.4	10.8	(5.6)	3.1
19	Ховд	30.5	18.0	(12.5)	6.8
20	Хөвсгөл	20.8	14.5	(6.3)	3.4
21	Хэнтий	23.7	16.2	(7.5)	4.1
22	Улаанбаатар	60.3	39.5	(20.8)	11.4
<b>Нийт дүн</b>		<b>599.1</b>	<b>416.4</b>	<b>(182.7)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Сангийн яам

3.10. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 445.3 тэрбум төгрөгөөр баталснаас 38.5 хувь буюу 171.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 273.7 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна.

3.11. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого 1,931.8 тэрбум төгрөг батлагдсанаас 0.1 тэрбум төгрөгөөр бууруулж, 1,803.0 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна.

**ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ЗАРЛАГА:**

**Нэг. Төсвийн урсгал зардал**

4.1.1. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар нийт урсгал зардлыг 25,304.6 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд Монгол Улсын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн өргөн



мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслөөр урсгал зардлын хэмжээг 1,299.1 тэрбум төгрөгөөр бууруулан төсөвлөжээ.

4.1.2. Улсын төсвийн урсгал зардлыг 2025 оны батлагдсан төсвөөс 1,149.5 тэрбум төгрөг, орон нутгийн урсгал зардлыг 648.9 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын санг 47.2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан байна.

4.1.3. Өмнө онд ЭМДС-ийн эмийн сан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өглөг 316.8 тэрбум төгрөгт хүрч өрийн дарамтад орсон, даатгалын сангийн орлогын эх үүсвэр дутагдалтай үед төрөөс үзүүлэх тусламж үйлчилгээний санхүүжилтийг 47.2 тэрбум төгрөгөөр бууруулан тодотгосон нь иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ доголдох эрсдэлтэй байна.

Хүснэгт 5. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар /тэрбум төгрөгөөр/

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт	2025 он		Зөрүү	Өсөлтийн хувь
	Батлагдсан	Тодотгол		
Улсын төсвийн урсгал зардал	19,158.4	18,008.9	(1,149.5)	(6.0)
ОН-ын урсгал зардал	4,414.8	3,765.9	(648.9)	(15.0)
Нийгмийн даатгалын сан	5,882.8	5,882.8	0.0	0.0
Эрүүл мэндийн даатгалын сан	2,293.9	2,246.7	(47.2)	(2.0)
Төсөв хоорондын шилжүүлэг	(6,445.3)	(5,898.8)	546.5	(8.0)
<b>Дүн</b>	<b>25,304.6</b>	<b>24,005.5</b>	<b>(1,299.1)</b>	<b>(5.0)</b>

Эх сурвалж: Сангийн яам

4.1.4. Улсын төсвийн урсгал зардлын 2025 оны тодотгосон дүн 6 хувиар буурсан нь дараах зардлуудаас хамаарч байна. Хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6. Улсын төсвийн урсгал зардлын харьцуулсан дүн

/тэрбум төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	2025 он		Зөрүү	Өсөлтийн хувь
	Батлагдсан	Тодотгол		
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,876.7	5,707.4	(169.3)	(2.9)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	574.3	555.0	(19.3)	(3.4)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233.6	200.6	(33.0)	(14.1)
Хангамж, бараа материалын зардал	106.6	100.3	(6.3)	(5.9)
Нормативт зардал	459.1	469.5	10.4	2.3
Эд хогшил, урсгал засварын зардал	147.5	79.5	(68.0)	(46.1)
Томилолт, зочны зардал	87.7	77.3	(10.4)	(11.9)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,351.7	1,062.0	(289.70)	(21.4)
Бараа үйлчилгээний бусад зардал	758.9	672.0	(86.90)	(11.5)
Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	1,251.9	1,247.8	(4.1)	(0.3)
Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	45.2	45.2	0.0	0.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,536.6	1,538.4	1.8	0.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	561.6	527.3	(34.3)	(6.1)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,649.8	2,238.7	(411.1)	(15.5)
Бусад урсгал шилжүүлэг	3,517.3	3,487.9	(29.4)	(0.8)
<b>Дүн</b>	<b>19,158.4</b>	<b>18,008.9</b>	<b>(1,149.5)</b>	<b>(6.0)</b>

Эх сурвалж: Сангийн яам

4.1.5. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд цалингийн зардлыг 6,356.0 тэрбум төгрөг буюу 171.8 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

4.1.6. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг 2025 оны тодотголын хүрээнд улс болон орон нутгийн ТЕЗ-дын нийт 12,882 орон тоог хасахаар тооцож, төсвийн



тодотголд 260.5 тэрбум төгрөгийн цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг бууруулан тооцоолсон байна.

4.1.7. Төрийн нууцад хамаарах байгууллагууд болон орон нутгийн төсвийн байгууллагын орон тоог оруулахгүйгээр ТЕЗ-дын сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-д заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн дүнг дунджаар тооцоолж үзэхэд 26.8 тэрбум төгрөгийн зардал гарахаар байгааг төсөвт төлөвлөөгүй байна.

4.1.9. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2025 оны төсвөөс 289.7 тэрбум төгрөгөөр бууруулан 1,062.0 тэрбум төгрөгөөр тодотгосон байна.

Хүснэгт 7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2025 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
	Батлагдсан	Тодотгол		
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,351.7</b>	<b>1,062.0</b>	<b>(289.7)</b>	<b>78.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,236.5	947.1	(289.4)	76.6
Мэдээллийн технологийн үйлчилгээ	56.2	55.9	(0.3)	99.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээгээр

#### **Хоёр. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал:**

4.2.1. УИХ-аас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,132.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 621 төсөл, арга хэмжээг 3,124.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

4.2.2. ЗГ-аас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,696.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 610 төсөл, арга хэмжээг 2,875.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгаснаар тухайн жилийн санхүүжилт 248.6 тэрбум төгрөгөөр буюу 8.0 хувиар буурч төлөвлөгдсөн байна.

4.2.3. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай дээрх хуулийн төслийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс гэрээ цуцлагдсан, худалдан авах ажиллагаа зарлагдаагүй, гэрээ байгуулагдаагүй ажлын болон тендерийн хэмнэлтийн дүнгээр 129 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнгээс 325.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцон бууруулж төлөвлөжээ. Энэ хүрээнд 126.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 74.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 16 төсөл, арга хэмжээ 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаас хасагдсан байна.

4.2.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хэмнэлтэд тооцож хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дараагийн онуудад төсөвт тусгах эсэх талаар тодорхой зохицуулалт хууль журамд тусгагдаагүй тул 2025 оны төсвийн төслөөс хасагдсан төсөл, арга хэмжээнүүдийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор эрэмбэлж төсөвт тусгах асуудлыг анхаарах шаардлагатай.

4.2.5. Төсвийн тодотголын төсөлд БОУАӨС-ын болон ЭХС-ын багцад нийт 147.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 77.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээг нэмж тусган үүнээс 3 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.



Хүснэгт 8. Шинээр хэрэгжүүлэхээр нэмж төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

/тэрбум төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТЭЗ	Ангилал	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт /Улаанбаатар/	БОУАӨС	Барилга байгууламж	2025	2025	41.8	41.8
2	Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл хэсгийн дээвэр болон байрны засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ЭХС	Их засвар	2025	2025	7.0	7.0
3	Дулааны гуравдугаар цахилгаан станцын дулаанжуулалтын тоноглолын өргөтгөл, шинэчлэл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ЭХС	Тоног төхөөрөмж	2025	2025	8.5	8.5
4	Дулааны гуравдугаар цахилгаан станцын турбингенератор №7 шинээр суурилуулах /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ЭХС	Тоног төхөөрөмж	2025	2026	30.0	5.0
5	Дулааны гуравдугаар цахилгаан станцын 50 мВт-ын турбин генератор №9 шинээр суурилуулах /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ЭХС	Тоног төхөөрөмж	2025	2026	60.0	15.0
<b>Нийт</b>						<b>147.3</b>	<b>77.3</b>

Эх сурвалж: Сангийн яам

4.2.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох, зарцуулахгүй байх асуудлыг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж баталсан.

4.2.7. Нэгдсэн Үндэстний Байгууллагын COP-17 дугаар Бага хурлыг 2026 оны 08 дугаар сард Монгол улсад зохион байгуулахтай холбоотойгоор "Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт /Улаанбаатар/" төсөл, арга хэмжээнд 2025 онд 50.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс 8.2 тэрбум төгрөгийн ажилд гэрээ байгуулсан ба үлдэгдэл 41.8 тэрбум төгрөгийг хэмнэлтэд тооцож хассан боловч тодотголын төсөлд "Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт" /Улаанбаатар/ нэрээр нэмж тусгасан, магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй байна.

4.2.8. 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар тухайн төсөл, арга хэмжээний үндсэн барилгын ажлын даалгавар, зураг төсөл болон төсвийг бүрэн боловсруулж батлуулаагүй байгаа бөгөөд 2025 онд буюу сүүлийн хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нь хугацаандаа хэрэгжихгүй байх, төлөвлөсөн 41.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тухайн онд бүрэн ашиглах чадахгүйд хүрэх эрсдэлтэй байна.

4.2.9. Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл хэсгийн дээвэр болон байрны засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөл, арга хэмжээнд 7.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй байна.

4.2.10. Дээрх дурдсан барилга байгууламж, их засварын 2 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг, зураг төсөл нь магадлалаар баталгаажаагүй байгаа нь төсөвлөлтийн шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд зураг төсвийг холбогдох байгууллагуудаар хянуулж баталгаажуулснаар төсөвт өртөг өөрчлөгдөж болзошгүй байна.



## ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ:

5.1. Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30,209.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31,575.1 тэрбум төгрөг, нийт гадаад зээл 1,542.4 тэрбум төгрөг, орон нутгийн үнэт цаас 1,516.1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,808.2 тэрбум төгрөгийн ашигтай, тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон төсвийн тэнцэл 1,365.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2025 он		Зөрүү
	Батлагдсан	Тодотгол	
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>36,435.6</b>	<b>32,540.2</b>	<b>(3,895.4)</b>
Тогтворжуулалтын сан	608.9	429.1	(179.8)
Үндэсний баялгийн сан	2,356.8	1,901.2	(455.6)
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО</b>	<b>33,469.9</b>	<b>30,209.9</b>	<b>(3,260.0)</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>33,431.5</b>	<b>31,575.1</b>	<b>(1,856.4)</b>
Урсгал зардал	25,304.6	24,005.5	(1,299.1)
Хөрөнгийн зардал	8,340.3	7,841.4	(499.0)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(213.4)	(271.8)	(58.4)
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ</b>	<b>38.3</b>	<b>(1,365.2)</b>	<b>(1,403.5)</b>
ДНБ-д эзлэх хувь	-	(1.5%)	(1.5%)
<b>СУУРЬ ЗАРЛАГА</b>	<b>30,258.1</b>	<b>28,401.7</b>	<b>(1,856.4)</b>
ДНБ-д эзлэх хувь	31.9%	31.6%	0.3%
<b>СУУРЬ ТЭНЦЭЛ</b>	<b>3,211.8</b>	<b>1,808.2</b>	<b>(1,403.5)</b>
ДНБ-д эзлэх хувь	3.4%	2.0%	1.5%

Эх сурвалж: Сангийн яам

5.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн ДНБ-ний 2 хувь буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” гэж заасан төсвийн төлөвлөлтийн шаардлагыг хангасан байна.

## ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:

6.1. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 33,399.9 тэрбум төгрөг, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 34,616.3 тэрбум төгрөг буюу ДНБ 38.5 хувьтай байна.

6.2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь (1,365.2) тэрбум төгрөгийн алдагдалтай байгаагаас гадаад зээлийн ашиглалт болох 1,542.4 тэрбум төгрөг болон нийслэлийн үнэт цаасны гаргалт болох 1,516.1 тэрбум төгрөг нь эх үүсвэртэй байна.

6.3. ЗГ-ын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,706.1 тэрбум төгрөг, ЗГ-ын дотоод үнэт цаас гаргалт 300.0 тэрбум төгрөгтэй тэнцсэнээр мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт (406.4) тэрбум төгрөгтэй тэнцэж байна.



## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, зарим яамдын эрхлэх асуудал, чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбоотойгоор шинэ бүтцийг дагалдуулан хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөтөлбөр, арга хэмжээг шилжүүлж, төсөвт зохицуулалт хийсэн байна.
2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл болон тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд тусгасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.
3. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого батлагдсан дүнгээс 3,895.4 тэрбум төгрөгөөр буурч, 32,540.2 тэрбум төгрөгт, тэнцвэржүүлсэн орлого батлагдсан дүнгээс 3,260.0 тэрбум төгрөгөөр буурч, 30,209.9 тэрбум төгрөгт тус тус хүрэхээр тооцсон байна. Төсвийн орлого буурахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,769.7 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 1,349.3 тэрбум төгрөг, дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 557.0 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж тооцсонтой холбоотой байна.
4. Нүүрсний үнэ дэлхийн зах зээлд буурч байгаатай холбогдуулан 2025 оны үнийн төсөөллийг шинэчлэн тонн тутамд 70.0 ам доллароор, экспортын хэмжээг өнгөрсөн оны түвшнээс бууруулахгүй байхаар төсөөлж төсвийн орлогын тооцооллыг шинэчилсэн байна.
5. Уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус эрсдэлтэй байгаа учир уул уурхайн бус орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт, үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.
6. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбоотойгоор Засгийн газрын шинэчилсэн бүтэц, бүрэлдэхүүнд нийцүүлсэн байдлаар Засгийн газар нь 16 яам, Ерөнхий сайд болон 19 сайдтай байхаар төсвийн тодотголыг өргөн мэдүүлж 8.4 тэрбум төгрөг, хуулиар тусгайлан байгуулаагүй 7 хороо, 3 зөвлөл, тэдгээрийн ажлын албыг татан буулгаж 11.2 тэрбум төгрөг, нийт 19.6 тэрбум төгрөгийн зардлыг буруулсан байна.
7. УИХ-аас баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албаны албан хаагчдын тоог 9 хувь бууруулахаар заасныг Төсвийн тодотголд хэрэгжүүлж эхлэхээр тооцсон нь чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийгээгүй, түүнд үндэслэсэн цогц төлөвлөгөөгүйгээр, механик аргаар бүх ТЕЗ нарын орон тоог жигд бууруулж байгаа нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах эрсдэлийг бий болгож байна.
8. ТЕЗ-д өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудын орон тоонд зохицуулалт хийх эрхийг олгох шаардлагатай байна.
9. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд “2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх” гэж заасан байна.



10. Энэ нь чиг үүргийн судалгааг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж орон тоогоо зорилтот түвшин хүртэл бууруулсан байгууллагад нэмж сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.
11. Өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх төрийн албан хаагчдад хуулиар олгох нэг удаагийн тэтгэлэг болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн зардлыг нэмэгдүүлэх үр дагавартай байна.
12. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хэмнэлтэд тооцож 2025 оны төсвийн төслөөс хасахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор эрэмбэлж дараагийн онуудын төсөвт тусгах асуудлыг анхаарах шаардлагатай байна.



Хавсралт 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө

/сая төгрөг/

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	2025 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
		Батлагдсан	Тодотгосон		
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b>	<b>185.0</b>	<b>185.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0	185.0	-	-
2	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0	100.0	-	-
3	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>106,372.5</b>	<b>105,149.0</b>	(1,223.5)	(0.0)
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	101,600.0	101,600.0	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,772.5	3,549.0	(1,223.5)	(0.3)
4	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	<b>510.0</b>	<b>510.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0	510.0	-	-
5	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b>	<b>831.3</b>	<b>831.3</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	831.3	831.3	-	-
6	<b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b>	<b>200.0</b>	<b>200.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	200.0	200.0	-	-
7	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b>	<b>4,000.0</b>	<b>4,000.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,000.0	4,000.0	-	-
8	<b>Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд</b>	<b>2,388.3</b>	<b>2,388.3</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,388.3	2,388.3	-	-
9	<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>20,954.3</b>	<b>21,289.1</b>	334.8	0.0
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	20,954.3	21,289.1	334.8	0.0
10	<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>115.9</b>	<b>115.9</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	115.9	115.9	-	-
11	<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>300.0</b>	<b>300.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	300.0	300.0	-	-
12	<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>16,100.0</b>	<b>9,100.0</b>	(7,000.0)	(0.4)
	Дипломат төлөөлөгчийн газрууд	13,000.0	6,000.0	(7,000.0)	(0.5)
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,100.0	3,100.0	-	-
13	<b>Сангийн сайд</b>	<b>21,278,121.4</b>	<b>18,370,131.2</b>	(2,907,990.2)	(0.1)
	Татварын ерөнхий газар	12,731,009.6	9,918,444.7	(2,812,564.9)	(0.2)
	үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	608,889.9	429,107.7	(179,782.2)	(0.3)
	Гаалийн ерөнхий газар	7,872,540.0	7,777,815.8	(94,724.2)	(0.0)
	Сангийн яам	248,209.1	247,508.1	(701.0)	(0.0)
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	417,000.0	417,000.0	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	9,362.6	9,362.6	-	-
14	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>81,156.8</b>	<b>81,138.8</b>	(18.0)	(0.0)
	Улсын бүртгэлийн ерөнхий газар	45,730.0	45,730.0	-	-
	Цагдаагийн ерөнхий газар	2,370.0	2,370.0	-	-
	Шүүх шинжилгээний ерөнхий газар	300.0	300.0	-	-



	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,052.5	1,052.5	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	31,704.4	31,686.4	(18.0)	(0.0)
15	<b>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд</b>	<b>412,848.1</b>	<b>314,636.5</b>	(98,211.6)	(0.2)
	Ашигт малтмал, газрын тосны газар	407,301.1	309,089.6	(98,211.5)	(0.2)
	Үндэсний геологийн алба	120.0	120.0	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,427.0	5,427.0	-	-
16	<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>43,187.2</b>	<b>43,187.2</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	43,187.2	43,187.2	-	-
17	<b>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд</b>	<b>2,226.9</b>	<b>2,162.8</b>	(64.1)	(0.0)
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,226.9	2,162.8	(64.1)	(0.0)
18	<b>Боловсролын сайд</b>	<b>5,534.8</b>	<b>6,534.8</b>	1,000.0	0.2
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,534.8	6,534.8	1,000.0	0.2
19	<b>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд</b>	<b>304.0</b>	<b>304.0</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	304.0	304.0	-	-
20	<b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>69,153.9</b>	<b>68,277.7</b>	(876.2)	(0.0)
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	1,000.0	1,500.0	500.0	0.5
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	3,035.1	3,035.1	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	65,118.8	63,742.6	(1,376.2)	(0.0)
21	<b>Зам, тээврийн сайд</b>	<b>110,656.0</b>	<b>110,656.0</b>	-	-
	Иргэний нисэхийн ерөнхий газар	80,000.0	80,000.0	-	-
	Зам, тээврийн яам	300.0	300.0	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	30,356.0	30,356.0	-	-
22	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>49,173.6</b>	<b>48,857.6</b>	(316.0)	(0.0)
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	49,173.6	48,857.6	(316.0)	(0.0)
23	<b>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд</b>	<b>8,663.3</b>	<b>8,663.3</b>	-	-
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,663.3	8,663.3	-	-
24	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>7,945.3</b>	<b>7,894.6</b>	(50.7)	(0.0)
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,945.3	7,894.6	(50.7)	(0.0)

Эх сурвалж: Сангийн яам

Хавсралт 2. Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл

/тэрбум төгрөгөөр/

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл			Тодотгол			Зөрүү		
						Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
							2025	2026		2027	2025
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.5	6.5	5.5	5.7	6.3	(2.5)	(0.8)	(0.2)	
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.2	5.0	4.0	9.5	7.0	6.4	2.3	2.0	2.4	
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	33,470.0	34,755.6	38,263.0	30,209.9	31,720.4	33,761.0	(3,260.1)	(3,035.2)	(4,502.0)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.2	33.2	32.8	33.6	30.9	29.3	(1.6)	(2.3)	(3.5)	
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	33,470.0	34,755.6	38,263.0	31,575.1	32,839.8	34,626.0	(1,894.9)	(1,915.8)	(3,637.0)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.2	33.2	32.8	35.1	32.0	30.0	(0.1)	(1.2)	(2.8)	
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-	-	-	(1,365.2)	(1,119.4)	(865.0)	(1,365.2)	(1,119.4)	(865.0)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-	-	-	(1.5)	(1.1)	(0.7)	(1.5)	(1.1)	(0.7)	
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	30,296.5	32,661.5	35,927.6	28,401.7	29,666.4	31,452.6	(1,894.8)	(2,995.1)	(4,475.0)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.9	31.2	30.8	31.6	28.9	27.3	(0.3)	(2.3)	(3.5)	
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	3,173.4	2,094.1	2,335.4	1,808.2	2,054.0	2,308.4	(1,365.2)	(40.1)	(27.0)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.3	2.0	2.0	2.0	2.0	2.0	(1.3)	-	-	
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	52,255.5	52,352.9	52,547.2	49,506.1	51,350.0	51,939.0	(2,749.4)	(1,002.9)	(608.2)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.0	50.0	45.0	55.0	50.0	45.0	-	-	-	
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,572.3	2,850.4	2,931.8	2,572.3	2,664.3	2,774.1	-	(186.1)	(157.7)	
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.7	2.7	2.5	2.9	2.6	2.4	0.2	(0.1)	(0.1)	

Хавсралт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын тодотгосон нийт зардал

/Тэрбум төгрөг/

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	2025 он		Зөрүү	Өөрчлөлтийн хувь
		Батлагдсан	Тодотгол		
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	37.6	33.1	(4.5)	(12.1)
2	Монгол Улсын Их Хурлын дарга	170.3	162.1	(8.2)	(4.8)
3	Монгол Улсын Ерөнхий сайд	627.0	384.9	(242.1)	(38.6)
4	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	5.5	5.0	(0.4)	(8.1)
5	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	31.9	27.3	(4.6)	(14.4)
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	329.8	261.8	(68.0)	(20.6)
7	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	14.9	12.2	(2.7)	(18.3)
8	Улсын ерөнхий прокурор	157.6	144.4	(13.1)	(8.3)
9	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	22.6	21.8	(0.7)	(3.3)
10	Монгол Улсын Ерөнхий аудитор	54.4	48.4	(6.0)	(11.0)
11	Авлигатай тэмцэх газрын дарга	56.9	55.0	(1.9)	(3.4)
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	21.7	20.9	(0.8)	(3.6)
13	Төрийн албаны зөвлөлийн дарга	19.4	15.2	(4.3)	(22.0)
14	Үндэсний статистикийн хорооны дарга	34.4	29.9	(4.5)	(13.0)
15	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	15.8	14.8	(0.9)	(6.0)
16	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	1.3	1.1	(0.2)	(12.8)
17	Шүүхийн сахилгын хорооны дарга	6.2	5.7	(0.4)	(7.0)
18	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	276.0	260.9	(15.1)	(5.5)
19	Монгол Улсын Шадар сайд	388.5	356.3	(32.2)	(8.3)
20	Монгол Улсын Шадар сайд	8.0	6.3	(1.8)	(22.0)
21	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	141.3	99.3	(41.9)	(29.7)
22	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга	19.3	-	(19.3)	(100.0)
23	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	13.5	-	(13.5)	(100.0)
24	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	20.1	-	(20.1)	(100.0)
25	Гадаад харилцааны сайд	262.3	261.7	(0.6)	(0.2)
26	Сангийн сайд	4,877.2	4,542.0	(335.2)	(6.9)
27	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1,725.4	1,625.1	(100.2)	(5.8)
28	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	49.0	47.0	(1.9)	(4.0)
29	Батлан хамгаалахын сайд	819.6	785.2	(34.3)	(4.2)
30	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	308.6	256.4	(52.1)	(16.9)
31	Боловсролын сайд	4,466.1	4,261.4	(204.7)	(4.6)
32	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4,495.7	4,459.6	(36.1)	(0.8)
33	Зам, тээврийн сайд	1,091.2	1,013.6	(77.5)	(7.1)
34	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	525.4	439.1	(86.2)	(16.4)
35	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	424.0	405.1	(18.9)	(4.5)
36	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	723.0	676.7	(46.3)	(6.4)
37	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	118.4	79.6	(38.9)	(32.8)
38	Эрчим хүчний сайд	298.4	366.0	67.6	22.6
39	Эрүүл мэндийн сайд	1,847.4	1,700.3	(147.1)	(8.0)
40	Орон нутаг	4,414.8	3,765.9	(648.8)	(14.7)
41	Нийгмийн даатгалын сан	5,882.8	5,882.8	-	-
42	ЭМ-ийн даатгалын сан	2,293.9	2,246.7	(47.2)	(2.1)
	<b>Нийт</b>	<b>37,096.9</b>	<b>34,780.9</b>	<b>(2,316.0)</b>	<b>(685.3)</b>

Эх сурвалж: Сангийн яам

**Хавсралт 4. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний судалгаа**

<b>Д/д</b>	<b>Засгийн газрын бүрэлдэхүүн /2024 он/</b>	<b>Засгийн газрын бүрэлдэхүүн /2025 он/</b>
1	Монгол Улсын Ерөнхий сайд	Монгол Улсын Ерөнхий сайд
2	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
3	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд
4	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд
5	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
6	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд
7	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд
8	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд
9	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
10	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд
11	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
12	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайд
13	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
14	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд
15	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
16	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
17	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
18	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд
19	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд.	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд.
20	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	
21	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга	
22	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	
23	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	

**Эх сурвалж: Сангийн яам**

Хавсралт 5. Татан буулгах хороо, зөвлөлийн судалгаа

/сая төгрөг/

№	Байгууллага	Хэмнэгдсэн төсөв
1	Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хороо	100,000.0
2	"Хархорум" хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо	-
3	Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын Үндэсний хороо	1,365,700.0
4	Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хороо	1,756,300.0
5	Аж үйлдвэржилтийн үндэсний хороо	1,754,200.0
6	Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо	1,518,300.0
7	Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны бүрэлдэхүүн	4,166,500.0
8	Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл	-
9	Сансрын бодлогын үндэсний зөвлөл	-
10	Эдийн засгийн бодлогын зөвлөлийн Ажлын алба	578,700.0
	<b>Нийт дүн</b>	<b>11,239,700.0</b>